



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар A/618

Алтай хот

Эзэмшил газрын талбай өөрчилж,
эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд 2 иргэний эзэмшиж байгаа газрын талбайг өөрчлөн 1-3 дугаар хавсралтаар баталж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.


2.Газар эзэмшсэн иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/206 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 26-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ



Аймгийн Засаг даргын 2020 оны
11 дугаар сарын 05-ны өдрийн 1618 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Өмнө олгогдсон газрын хэмжээ /м2/	Шинээр олгох газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил
1	Ч.Болормаа	Орон сууц	80	95	14	Түмэн баг
2	Н.Батдорж	Үйлчилгээ	120	150	4	Оргил баг

ИРГЭН ЧИМЭДДАМБА ОВОГТОЙ БОЛОРМАА (ДЮ68031408) - ИЙН
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 8208.....

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Түмэн баг



Аймгийн Засаг даргын
2020 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн
1/618 дугаар захирамжийн дагуу хавсралт



Огноо: 2020-06-16

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139561.670	289147.396	10.56	1-2
2	5139571.430	289143.377	9.00	2-3
3	5139574.494	289151.840	10.56	3-4
4	5139564.719	289155.835	8.97	4-1

Талбайн хэмжээ: 95.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

